

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ
МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛ, ДҮГНЭСЭН АРГАЧЛАЛ**

№	Шалгах үзүүлэлт	Даалгаврын гүйцэтгэл	Өгөх үнэлгээ
1	Хяналтын журмаар гомдолд гаргахад хуулиар тогтоосон хэлбэр, агуулгын шаардлагыг хангасан байдал <i>(ЭХХШтХ-ийн 40.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг)</i>		
	- гомдлыг ямар шүүхэд гаргаж байгааг даалгаврын өгөгдөлд нийцүүлэн зөв бичсэн эсэх	МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД	
	- гомдол гаргагч этгээдийн мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу бүрэн тусгасан эсэх	Гомдол гаргагч: Шүүгдэгч Б.Б-ийн өмгөөлөгч ...-ийн ... Хаяг: ... дүүргийн ... дугаар хорооны, ... тоот	
	- аль шүүхийн ямар шийдвэрийг гомдол гаргаж байгааг даалгаврын өгөгдөлд тусгаснаар зөв бичсэн эсэх	Шүүгдэгч Б.Б-ийн өмгөөлөгч ...-ийн ... миний бие Эрүүгийн ... дугаартай хэргийн хянан шийдвэрлээд гарсан Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ... оны ... дүгээр сарын ...-ний өдрийн ... дугаартай магадлалыг эс зөвшөөрч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлүүдээр гомдол гаргаж байна.	
	- анхан шатны шүүхийн шийдвэрт заасан хэргийн товч утга;	Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газраас Б.Б-г "...2023 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн ... дугаар хорооны нутаг дэвсгэрт ... улсын дугаартай ... загварын тээврийн хэрэгслээ хохирогч М.М-д ... улсын дугаартай ... загварын тээврийн хэрэгсэл болон 10 сая төгрөгөөр харилцан солилцоно гэж итгүүлэн хохирогчийн автомашин болон мөнгийг нь урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг ашиглан, хууран мэхэлж авч 29,000,000 төгрөгийн хохирол учруулсан..." гэх үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн. Хэргийг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлээд тус шүүхийн ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаартай шийтгэх тогтоолоор Б.Б-г ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн буруутайд тооцож, 1.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 1,000,000 (нэг сая) төгрөгөөр торгох ял оногдуулсан. Уг шийтгэх тогтоолд Б.Б-ийн өмгөөлөгч нарын гаргасан давж заалдах гомдлыг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлээд тус шүүхийн ... оны ... дүгээр сарын ...-ний өдрийн ... дугаартай магадлалаар давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээн шийдвэрлэсэн.	0-3
	- гомдлын үндэслэлийг ялгагдахаар тодорхой тусгасан эсэх	Шалгах үзүүлэлтийн 2	
	- гомдлын шаардлага буюу давж заалдах шатны шүүхэд гаргаж байгаа хүсэлтээ тодорхой, ялгагдахаар бичсэн эсэх	Шалгах үзүүлэлтийн 3	
	- гомдлын үйлчлүүлэгчдээ танилцуулж баталгаажуулсан эсэх <i>(ЭХХШтХ-ийн 40.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг)</i>	Хяналтын журмаар гаргасан гомдолдтой танилцсан: Б.Б	

Гомдлын хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон байдал		
<p>2 - ЭХХШТХ-ийн 40.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт "...1.3.хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн;..."</p>	<p>Анхан болон давж заалдах шатны шүүхүүд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийг хэрэглэхдээ “Залилах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар гарсан Улсын дээд шүүхийн 2006 оны 51 дүгээр тогтоолоор тайлбарласнаас өөрөөр тайлбарлан хэрэглэсэн.</p> <p>Тус тайлбарын 10-д “...Залилан мэхлэж авах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, итгэл эвдэх арга дээр үндэслэгдсэн, шунахай сэдэлтээр, дан ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг бол иргэний эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрх, харилцан тодорхой үр дүнд хүрэхийн тулд хийгддэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, үүнийгээ гэрээний нэг тал урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал /хохирогч/ нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзнэ...” гэж, 14-т “...Худалдах-худалдан авах, ... гэрээгээр халхавчлан бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг нь анхнаасаа хууль, гэрээнд заасан эд хөрөнгийг нийлүүлэхгүй, үнэ болон хөлсийг зохих журмаар төлөхгүй байх гэсэн субъектив санаа зорилгыг агуулж, түүнийгээ хэрэгжүүлсэн байдаг ... зэрэг хэлбэрээр илэрнэ...” гэж тус тус тайлбарласан байна.</p> <p>Хохирогч М.М, шүүгдэгч Б.Б нарын хооронд “...2023 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Ө.Г, Б.Б нарын гэр бүлийн эзэмшилд байсан 62 сая төгрөгийн үнэ бүхий ... улсын дугаартай ... “Lexus JS-300” загварын тээврийн хэрэгслийг М.М, Ө.Б, нарын гэр бүлийн дундын өмчлөлийн 17 сая төгрөгийн үнэ бүхий ... улсын дугаартай “Nissan X-trail” загварын тээврийн хэрэгсэлээр арилжиж, зөрүүд нь М.М-ээс 10 сая төгрөг өгөхөөр харилцан тохиролцож арилжааны гэрээг амаар байгуулан, тэр өдрөө автомашинуудыг болон эзэмших эрхийн гэрчилгээг харилцан хүлээлцсэн.</p> <p>Тэдний хооронд хийгдсэн гэрээ нь Иргэний хуулийн 189 дүгээр зүйлд заасан талуудын чөлөөт байдлын үндсэн дээр хийгдсэж, гэрээний дагуу шилжүүлэх ёстой авто машинуудыг харилцан хүлээлцэж тус тусын эзэмшилд шилжүүлсэн, Б.Б-ний нөхөр Ө.Г нь дээрх Лексус маркийн тээврийн хэрэгслийг шилжүүлэн авах зорилгоор ББСБ-ын зээлийн эргэн төлөлтийг 2023 оны 12 дугаар сар хүртэл хугацаанд төлж байсан зэрэг үйл баримт тогтоогдсон ба тэдний хооронд үүсэн харилцаа гэрээний эрх зүйн харилцаа үүсэн гэж үзэхээр байна.</p> <p>Давж заалдах шатны шүүх арилжааны зүйл болох Nissan X-trail автоманыг худалдан борлуулсанаас олсон 17,000,00 төгрөг, арилжааны зүйлийн зөрүү 10,000,000 төгрөгийг тус тус ББСБ-д төлөөгүй нь залилан мэхлэх гэмт хэргийн үндсэн шигжийш агуулж байгаа гэж дүгнэсэн нь үндэслэлгүй дүгнэлт болсон.</p> <p>Түүнчлэн Б.Б-ийн нөхөр Ө.Г нь ББСБ-д төлөх зээлээ 2023 оны 12 дугаар сарыг дуусах хүртэл хугацаанд төлж байсан нь тэд анхнаасаа автомашиныг шилжүүлэхгүй байх санаа зорилгогүй байсан болохыг нотлож байхад анхан болон давж заалдах шатны шүүхүүд энэ нөхцөл байдлыг харгалзан үзээгүй нь УДШ-ийн 2006 оны 51 дүгээр тогтоолын 6-д “...Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг эзэмших, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, эсхүл хагасыг нь хийнэ гэсэн субъектив</p>	<p>0-8</p>

		<p>санаа зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бий болсон байдгаараа залилан мэхлэх гэмт хэрэг нь гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгагдана...” гэж заасанд нийцээгүй байна.</p> <p>УДШ-ийн 2006 оны 51 дүгээр тогтоолын 8-д “...гэнэтийн ... өвчин эмгэг ... зэрэг талуудаас үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй...” байхаар тайлбарласан.</p> <p>Б.Б-ийн нөхөр Ө.Г-ийн архинд донтох өвчин сэдэрч тэрээр ажил хөдөлмөр огт эрхлэхгүй орлого олохоо больсоноос шалтгаалан төдийгүй архины хамаарлаас болж, ББСБ-ын төлдөг зээлээ 2024 оны 1 сараас төлөөгүй үйл баримт хэрэгт тогтоогдсон. Б.Б-ий нөхрийн архаг хууч өвчин гэнэт сэдэрсэн нь түүнээс үл хамаарах нөхцөл байдал бөгөөд тэрээр үүнийг урьдчилан тооцоолох боломжгүй гэнэтийн өөрчлөлтийг нь залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй байх талаар УДШ-ийн тогтоолд тайлбарласныг шүүх анхаарч үзэх ёстой байсан.</p> <p>Энэхүү үйл баримт нь УДШ-ийн 51 дүгээр тогтоолын 7-д “...Гэрээний харилцаа нь Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсч, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэж байсны эцэст эрсдэлд орсны улмаас үүссэн маргааныг, өөрөөр хэлбэл, гэрээний эрсдэлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй...” гэж заасанд мөн хамаарч байна.</p>	
	<p>Гомдлын шаардлагаа буюу хяналтын шатны шүүхэд гаргаж буй хүсэлтээ тодорхойлсон байдал (ЭХХШтХ-ийн 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)</p>		
3	<p>- гомдлыг хэрхэн шийдвэрлүүлэх саналаа даалгаврын өгөгдөлд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлсон эсэх (ЭХХШтХ-ийн 40.8 дугаар зүйлийн 1.2 дахь заалт)</p>	<p>Иймд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаартай шийтгэх тогтоол, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ... оны ... дүгээр сарын ...-ний өдрийн ... дугаартай магадлалыг тус тус хүчингүй болгож, Б.Б-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон, түүнийг цагаатгаж өгнө үү.</p>	0-4